



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 14/62

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх “шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах ажил, шил” ажиллагааг хэрэгжүүлэхээр тогтсоныг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Чиглэл хүргүүлэх тухай” 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 тоот албан бичиг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.15, 5.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн хэмжээнд авлигатай тэмцэх “шүүр” ажиллагааны хэрэгжилтийг хангаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Чиглэл хүргүүлэх тухай” 2023 оны ХЭГ/595 тоот албан бичигт заасан хууль тогтоомж, шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдийг олж, шалган тогтоох үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө гарган батлуулж, ашиг сонирхлын мэдэгдэл, нууцын баталгаа гарган ажиллахыг Ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Шаардлагатай тохиолдолд Ажлын хэсгийн гишүүдийн ажил үүрэгт зохицуулалт хийж, ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж ажиллахыг холбогдох газар, нэгжийн дарга нарт даалгасугай.

4.Ажлын хэсэгт шаардлагатай баримт, материалыг заасан хугацаанд гаргаж өгөх, чиглэлд заасан үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн бүх дарга нарт үүрэг болгосугай.

5.Шалгалтын дүнг 2023 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Ө.Мөнгөнжигүүр)-т үүрэг болгосугай.

6.Ажлын хэсгийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Дотоод аудитын алба (Б.Мөнх-Очир)-нд даалгасугай.

7.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Дотоод аудитын алба (Б.Мөнх-Очир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2023 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн  
14/16 дугаар тушаалын хавсралт



**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн  
ахлагч:

Ө.Мөнгөнжигүүр  
(Дотоод аудитын албаны менежер)

Гишүүд:

Д.Түвшинбаяр  
(Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын  
Агаарын харилцааны тасгийн дарга)

О.Ган-Эрдэнэ  
(Захиргаа, удирдлагын газрын менежер)

П.Батбаяр  
(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын  
мэргэжилтэн)

Д.Сувдаа  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа,  
хүний нөөцийн газрын менежер)

Д.Ариунтуяа  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний  
нөөцийн газрын ахлах мэргэжилтэн)

Ж.Зулцэцэг  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний  
нөөцийн газрын ахлах мэргэжилтэн)

П.Гантөгс  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын  
навигацийн үйлчилгээний газрын менежер)

Нарийн бичгийн  
дарга:

Э.Золзаяа  
(Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн  
мэргэжилтэн)

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн  
А/б. дугаар тушаалын хавсралт



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА САЛБАР НЭГЖҮҮДЭД “ШҮҮР”  
АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

№

Улаанбаатар хот

Нэг. Ажлын хэсгийн зорилго

Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд “нийтийн албанд танилын хүрээ, зүй бус нөлөөллөөр хуульд заасан шаардлага хангаагүй этгээд томилогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх”, “ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж нийтийн албанд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх”, “авлига, албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх” зарчмыг хангах үүднээс авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэн цэвэрлэх, төрийн алба, төрийн өмчийг “шимэгчид”-ээс салгах чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргах.

Хоёр. Хэрэгжүүлэх хугацаа

Шалгалтыг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Ажлын хамрах хүрээ

Ажлын хэсэг шалгалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Чиглэл хүргүүлэх тухай” 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 тоот албан бичгээр ирүүлсэн дараах чиглэлийн хүрээнд явуулна. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын шаардлагыг хангаагүй, дүйцүүлэн тооцох журам зөрчин томилогдсон,
2. Төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалд хууль тогтоомжоор тогтоосон тусгай шаардлагыг хангаагүй томилогдсон,
3. Төрийн жинхэнэ албан тушаалд ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй, тэнцээгүй томилогдсон, Төрийн албаны тухай хууль, уг хуулийг дагаж гарсан дүрэм, журмыг зөрчиж томилогдсон,
4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, түүнчлэн тухайн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын дүрмээр тогтоосон журмын дагуу томилогдоогүй, ажил үүргийн тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын болон бусад шаардлагыг хангаагүй томилогдсон,
5. Хуульд заасны дагуу байгуулагдан ажиллаж байгаа хороо, зөвлөл, зохицуулах зөвлөлийн орон тооны албан тушаалд тухайн хуулиар тогтоосон шаардлагыг хангаагүй томилогдсон,
6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан “Хувийн ашиг

- сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон, хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргээ биелүүлээгүй,
7. Авлигатай тэмцэх газраас ашиг сонирхлын зөрчилтэй гэж тогтоосон ч төрийн албанд томилогдсон,
  8. Хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчин томилогдсон томилох эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээд,
  9. Нийтийн албан тушаалтны удирдах болон харьяалах, зохицуулалтад шууд хамаарах салбарт түүний хамаарал бүхий этгээд ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг, энэ байдал нь давуу байдал үүсгэхүйц нөхцөл үүсгэсэн этгээд,
  10. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн,
  11. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон этгээдийг тус тус олж шалган тогтоох.

#### Дөрөв. Үүрэг хариуцлага

Шалгалтад хамрагдаж буй нэгж, ажилтан:

- Шаардлагатай мэдээлэл, материал, баримтыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх,
- Шалгалтыг явуулахад холбогдох программ хангамжид нэвтрэн орох нөхцөл бололцоогоор хангах,

Ажлын хэсэг:

- Шалгалтыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах, шаардлагатай тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад танилцуулан нэмэлт ажлууд гүйцэтгэх,
- Шалгалтын ажлын явцад хамрагдаж буй газар, нэгж, ажилтны талаарх мэдээллийн нууцыг хадгалах,

#### Тав. Тайлагнах

Ажлын хэсэг шалгалтын дүнг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дотор Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад танилцуулж, дүнг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

---oOo---